

XIII-XV ЗУУНЫ МОНГОЛ ХЭЛНИЙ БИЧГИЙН ДУРСГАЛУУДЫН
ҮГИЙН САНГ ДАВТАМЖААР ШИНЖЛЭХ НЬ

Б.Энхсүвд

Хураангуй: Монгол хэлний үгийн сан хийгээд түүний бүрэлдэхүүний тухай гадаад, дотоодын эрдэмтэн олон талаас нь судалж эрдэм шинжилгээний өгүүлэл, бие даасан бүтээлийг өнөөдрийг хүртэл тасралтгүй хийж, хэвлэн гаргасаар байна. Тэдгээр судалгаа нь ихэвчлэн үгийн гарал, тухайлсан нэг түүхэн сурвалжийн судалгаа хийгээд орчин цагийн монгол хэлний үгийн сан судлалтай холбоотой юм. Харин монгол хэлний олон бичгээр буй түүхэн сурвалжуудын үгийн санг нэгтгэсэн нэгдмэл нэг санг хараахан гаргаагүй байна. Тиймийн тул бид энэхүү өгүүлэлдээ монгол хэлний бичгийн дурсгалуудын суурь үндэс болсон дундад үеийн монгол хэлний дурсгал буюу XIII-XV зууны үед хамаарах монгол, дөрвөлжин, араб-перс болон хятад бичгээр уламжлагдан ирсэн 270 гаруй дурсгалыг гол судлагдахуунаа болгож, тухайн бичгийн дурсгалуудын үгийн санг харьцуулав. Ингэхдээ тэрхүү үгийн санд тулгуурлан тухайн үеийн хамгийн өргөн хэрэглээтэй үгсийг тодруулахаас гадна сурвалж бичгүүдэд тохиолдох нийтлэг үгийг гарал, үгийн аймаг, утга болон орчин цагийн монгол хэлний хэрэглээний талаас нь авч үзэв.

Түлхүүр үг: нийтлэг үг, уугуул үг, үгийн сангийн утга, давтамж, хэрэглээ

Удиртгал

Үггүй хэл гэж байдаггүй. “Аливаа хэлний бүх үгийг тухайн хэлний үгийн сан гэдэг” (Өнөрбаян нар, 2020: 180). “Үгийн сан нь үгийн сан судлалын үндсэн нэгж, түүний гол судлагдахуун бөгөөд өөрөөр хэлбэл цорын ганц судлагдахуун нь байдаг” (I. Mel’čuk, 1995: 167).

Үгийн сан (анг. lexeme, lexicography, lexicon орос. лексема) нь тухайн хэлээр хэлэлцэгч ард түмний түүх, соёлын гэрч болдгоороо хэлний бусад бүтцээс онцлогтой бөгөөд хамгийн хувьсамтгай шинж чанартай байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн нийгмийн хөгжил дэвшилт, өөрчлөлт шинэчлэлтэй шууд холбоотой учраас түүнийг дагаж үгийн санд үг нэмэгдэх, хасагдах үйл явц тасралтгүй үргэлжилсээр байдаг билээ. Монгол хэлний үгийн санд ч тэрхүү үйл явц тасралтгүй үргэлжилсээр байгаа бөгөөд монгол оронд болсон нийгмийн хувьсал өөрчлөлт, олон улсын харилцаа холбоог даган монгол хэлний үгийн санд нэлээд өөрчлөлт гарсныг үгийн сангийн бүрэлдэхүүнээс тодорхой харж болно.

Үгийн сан болон түүний бүрэлдэхүүнийг судалдаг хэл шинжлэлийн салбар ухааныг *үгийн сан судлал* (гр. lexicologos, lexicos, анг. lexicology, орос. лексикологи, фр. lexicologie) гэх бөгөөд тухайн хэлний үгийн санг судалдаг онолын салбар юм. Үгийн сангийн судлал нь түүхэн хөгжлийн урт замыг туулж, аажмаар бүрэлдэн тогтсон хэлний үгийн санг судалж, тогтолцоог нь зөв тогтооход чухал ач холбогдолтой. Учир нь “аливаа хэлний үгийн сан нь салангид үгсийн тооны энгийн нийлбэр биш тодорхой систем гэж үздэг билээ” (Сүхбаатар, 2014: 7) Мөн тус салбар ухаан нь үгийг судлахдаа утга зүй, нэр зүй, гарал судлал гэх мэтийн салбар ухаануудтай холбон судалдаг.

Монгол хэлний үгийн сан судлалд орчин цагийн монгол хэлний үгийн сан, харь үгийн судалгаа болон тусгайлсан нэг түүхэн сурвалжийн судалгааг голлосон байна. Тухайлбал, орчин цагийн монгол хэлний үгийн санг хамгийн анх тусгайлан судалсан бол Б.Ринчен (1950) бөгөөд түүний дараагаар Ш.Лувсанвандан (1951), Ц.Өлзийхутаг (1979), ШУА “Орчин цагийн монгол хэлний үгсийн сангийн судлалын үндэс” (1986, 1990), Ж.Төмөрцэрэн (2001), Ш.Баттөгс нар (2003), Н.Нансалмаа (2005, 2015), Д.Батчулуун (2009) болон одоогоор хэл шинжлэлийн хамгийн цогц бүтээл болсон “Монгол хэл судлал” хэмээх XV боть (2022)-ийн “Үгийн сан, утга, найруулга судлал” (Баттөгс нар, 2020: 15-69) хэмээх I ботийн 1-р бүлэгт монгол хэлний уугуул болон харь үгийн судалгаа 2-р бүлгийн 1-р зүйлд үгийн гарлын судалгааны тухай, “Үсэг зүй” (Шагдарсүрэн нар, 2022: 187-227) хэмээх VII ботид монгол хэлийг бусад өөр бичиг үсгээр тэмдэглэсэн ирсэн тухай тэр дундаа бидний судалгаанд хамаарах хятад, араб үсгээр монгол хэлийг тэмдэглэж ирсэн хийгээд уламжилж ирсэн дурсгалуудын тухай дурджээ. “Үгийн сан, утга зүй” (Шагдарсүрэн, 2022: 27-70) хэмээх X ботийн 1-р бүлэгт үгийн сангийн бүрэлдэхүүнийг уугуул болон харь үгийн хүрээнд авч үзсэнээс гадна тэдгээр хэлний харилцан нөлөөллийг дурдсан байдаг. Мөн тус XV ботийн V боть болох “Түүхэн хэл зүй” (Төмөртоого, 2022: 341-400) хэмээх бүтээлийн 3-р бүлэгт монгол хэлний уугуул үгийн бүрэлдэхүүнийг авч үзсэн бөгөөд нийт үгийн санг бус харин эртний монголчуудын төр улс, шашин мөргөл болон аж амьдралын олон талыг хамарсан үгийн сангийн нийтлэг шинжийг холбоо болон хоршоо үгээр төлөөлүүлэн авч үзсэн байна.

Харин монгол хэлэнд орсон харь үгийн тухай Б.Я.Владимирцов (1911), Н.Поппе (1955), Ж.Клоузон (1959, 1960), Ц.Дамдинсүрэн (1961), Ю.Н.Рерих (1975), Д.Төмөртоого (1969), Л.Хүрэлбаатар (1979), О.Сүхбаатар (1984, 1988), Х.Серрюс (1974), Ж.Кара (1999), Я.Ганбаатар (2014), С.Мөнхсайхан (2014), Л.Лигети (1960), Г.Дерфер (1985), Го.Мижиддорж (1964), Л.Мишиг (1970), В.Розицки (1994) зэрэг олон арван эрдэмтэн судалгааны бүтээл хэвлүүлсэн байна. Мөн түүнчлэн монгол хэлний үгийн гарлын судалгаанд холбогдох толь бичгүүд ч цөөнгүй хэвлэгдсэн. Тухайлбал, гадаадын эрдэмтдээс Ж.Клоузон, “An Etymological Dictionary of Pre-Thirteenth Century Turkish” (1972), С.А.Старостин, А.В.Дыбо нарын “Etymological Dictionary of Altaic Language” (2003), дотоодын эрдэмтдээс Н.Балжинням, “Монгол хэлний гадаад үгийн толь” (2005, 2008), О.Сүхбаатар, “Монгол хэлний харь үгийн толь” (1997, 1999, 2014), Сэцэнцогт, “Монгол үгсийн язгуурын толь” (1988), Д.Төмөртоого, “Монгол хэлний үгийн гарлын толь” (2018) гэх мэтийг дурдаж болно. Үүнээс гадна тухайлсан нэг сурвалж болон тухайлсан нэг бичгээрх дурсгалын үгийн сангийн талаар Н.Поппе (1927), Ф.В.Кливиз (1949, 1950, 1951), Х.Лувсанбалдан (1961), Ж.Кара (1964), И.де. Рахевилц (1972), Ш.Чоймаа (2002, 2011), Ё.Жанчив (2005), Д.Төмөртоого (2006), М.Баярсайхан, О.Дэмчигмаа зэрэг гадаад дотоодын нэлээдгүй эрдэмтэд судалсан байдаг.

Бид энэхүү судалгааны ажлаараа *дундад үеийн монгол хэл* (анг. middle Mongolian language, орос. средний монгольский язык) буюу XIII-XV зууны үеийн монгол хэл, бичигт хамаарах монгол, дөрвөлжин, хятад, араб-перс бичгээр буй нийт 270 гаруй монгол хэлний түүхэн сурвалж бичгийн үгийн санд тулгуурлан монгол хэлний *уугуул үг* (анг. vernacular word, ор. исконная лексика)-ийн санд хамаарах үг болон бичиг бүрийн үгийн санг хооронд нь харьцуулан тэдгээрт тохиолдох *нийтлэг үг* (анг. common words, ор. лексическая общность)-ийг тодруулан гаргахыг зорилоо. Тодруулбал, монгол ба хятад, монгол ба дөрвөлжин, монгол ба араб-перс, хятад ба араб-перс, хятад ба дөрвөлжин бичиг, дөрвөлжин ба араб-перс бичгээр буй дурсгалыг харьцуулан тэдгээрт нийтлэг тохиолдож буй үгсийг үгийн гарал, үгийн аймаг, утгын ангилал хийгээд орчин цагийн монгол хэлний үгийн сантай харьцуулан хэрэглээний байдлыг гаргав.

Дундад үеийн монгол хэлний нийтлэг үгийн ерөнхий тойм. Монгол хэлний бичгийн эртний дурсгалуудын үгийн санг судлахдаа нийт үгийн санг гаргахаас гадна бичиг тус бүрийн үгийн сан болоод тэдгээрийг харьцуулах, цаашлаад дөрвөн өөр бичгээр бичигдсэн дурсгалуудын үгийн санг гаргах нь тухайн бичгүүдэд нийтлэг тохиолдох ямар ямар үг байгааг

харж болох сайн талтай. Мөн түүгээр дамжуулан тухайн үеийн нийгмийн байдал, харилцаа холбоо зэрэг соёлын талыг ч тодруулж болохоос гадна хамгийн гол нь монголчуудын уугуул үгийн сан, тэр дундаа хамгийн өргөн хэрэглээтэй үгсийг мэдэх боломжтой болох юм.

Дээр дурдсан хоёр бичгээр буй дурсгалд тохиолдож байгаа нийтлэг үгийн санд нийт 1233 үг байх бөгөөд нэр үг тэр дундаа жинхэнэ нэр голлож байна. Харин төлөөний үг хамгийн цөөн тохиолдох ажээ.




График 1. Нийтлэг тохиолдох үгийн үгийн аймгийн ангилал

Харин орчин цагийн монгол хэлэнд хэрэглэгдэх байдлыг авч үзэхэд нийт үгийн сангийн 81% нь өдгөө ч идэвхтэй хэрэглэгдэж байна.



График 2. Нийтлэг тохиолдох үгийн хэрэглээ

Ийнхүү бичиг тус бүрийн үгийн санг харьцуулахад харьцуулал бүр өөр өөрийн гэсэн онцлог шинжийг харуулж байна. Тэдгээрийн үгийн гарал, утга болон хэрэглээний онцлогийг доор дэлгэрүүлэн авч үзье.

Дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалуудын үгийн сангийн харьцуулал

А. Монгол ба хятад бичгээрх дурсгалын нийтлэг үг. Монгол хэлээр бичигдсэн эртний дурсгалуудын дотор хамгийн их үгийн сантай нь монгол бичиг болон хятад бичгээр буй дурсгалууд бөгөөд үгийн санд нийтлэг тохиолдох үгс ч хамгийн олон байх аж. Энэ санд нийтлэг тохиолдож буй нийт 605 үг байх ба энэ нь нийтлэг тохиолдох нийт үгийн сангийн 46 орчим хувийг эзэлж байна.

Тус хоёр бичгээр бичигдсэн дурсгалын нийтлэг үгийн санг авч үзэхэд үйл үг хамгийн их давтамжтай буюу 236 байгаагаас 193 үг нь орчин цагийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглэгдэж байна. Жишээлбэл, *дага-*, *яа-*, *байгуул-*, *огоор-*, *дуртга-*, *учир-* гэх мэт. Харин нэр үгийн хувьд жинхэнэ нэр давамгайлах бөгөөд *хөвгүүд* хэмээх үг хамгийн их давтамжтай буюу 109 удаа тохиолдох аж. Түүний дараагаар *шалтгаан* 71, *түүгээр* хэмээх төлөөний үг 60, *чин* хэмээх хятад гаралтай үг 57 удаа тус тус тохиолдож байна. Гарлын хувьд, хятад, түрэг, төвөд, санскрит, араб-перс хэлнээс гаралтай 25 үг тохиолдох бөгөөд хамгийн олон нь хятад хэлнээс орж иржээ. Жишээлбэл, хятад хэлнээс *чинсан*, *гүнж*, *тайш*, *люшо* (*сахин хамгаалагч*) гэх мэт ихэвчлэн албан тушаал, зэрэг дэвийн нэр; түрэг, уйгур хэлнээс *хана-*, *харш*, *таш* (*чулуу*) гэх мэт соёлын үг хэллэг; перс хэлнээс *тоть*, *цацар*, *хилэн* гэх мэт амьтан, эд зүйл хийгээд шашны холбогдолтой үг хэллэг орж ирсэн байна. Харин туслах үгийн дотор “мөн, бас” хэмээх утгатай *тахь* гэх сул үг олонтоо давтагдаж байгаа бөгөөд энэхүү сул үг нь өвөг алтай хэл болон эртний түрэг хэлэнд ч мөн энэ утгаар хэрэглэгдэж байжээ. Харин тус үг нь дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалууд дундаас зөвхөн монгол болон хятад бичгээрх сурвалжид л тохиолдох ажээ.

Монгол бичиг болон хятад бичгээр буй сурвалжуудад нийтлэг тохиолдож байгаа үгийн утгын сан бол маш өргөн бөгөөд олон талыг хамарсан арвин сан юм. Тиймээс ч эдгээр үгийн 80 (444 үг) орчим хувь нь орчин цагийн монгол хэлэнд идэвхтэй хэрэглээний үг байсаар байна. Үүнээс гадна тус санд нийтлэг тохиолдох 41 оноосон нэр гарч байгаа бөгөөд тэр дунд хүний нэр зонхилж байна.

Б. Монгол ба дөрвөлжин бичгээрх дурсгалын нийтлэг үг. XIII-XIV зууны үеийн монгол хийгээд дөрвөлжин бичгийн дурсгалын нийтлэг үгийн сан нь нийт 157 үгтэй бөгөөд үүнээс 105 монгол хэлний уугуул үг, 27 харь гаралтай үг болон 25 оноосон нэрээс бүрдэж байна. Харь гаралтай үгсийн дотор санскрит хэлнээс орж ирсэн үг дийлэнх байхаас гадна грек хэлний *ном*, *титэм*; перс хэлний *ил*; түрэг уйгур хэлний *ан*, *тэхимлэг*, *ариун*, *хөрөг*; хятад хэлнээс *сан*, *гийдэнхүү*, *шан*, *лав*, *лянхуа* гэсэн үг тус тус тохиолдох ажээ. Харин оноосон нэрийн хувьд хүний нэр, газар усны нэр цөөнгүй гарч байна.

Монгол ба дөрвөлжин бичгээр буй дурсгалын нийтлэг тохиолдох уугуул үгийн санд 63 жинхэнэ нэр байх бөгөөд тэр дундаа *бодисадва* хэмээх үг хамгийн олон давтамжтай буюу 215 удаа гарч байна. Мөн тус хоёр бичгээрх дурсгалын үгийн санг ажиглахад бурхан шашны холбогдолтой үг хамгийн түгээмэл байх ба тэдгээр нь ихэвчлэн олон тооны дагавраар бүтсэн үгс байх ажээ. Жишээлбэл, *тэнгэр нэр*, *мунхгууд*, *тойд*, *хутагтан*, *бурхад* гэх мэт. Албан тушаалын нэрсийн хувьд ч мөн адил олны утга заасан үгс байх бөгөөд тэдгээр нь ихэвчлэн дөрвөлжин бичгийн дурсгалд хамгийн олон давтамжтай байна. Жишээлбэл, *алба* хэмээх үг нийт үгийн санд 92 тохиолдож байгаагаас 79 нь дөрвөлжин бичгээрх дурсгалд тохиолдож байна. Мөн бомбын шашны санваартнуудыг нэрлэх *шинишингүүд* хэмээх үг 72 удаа тохиолдохоос 68 нь, харин исламын санваартнуудыг заах *dašmad* хэмээх үг 13-аас 10 нь дөрвөлжин бичгийн дурсгалд тус тус тохиолдож байна. Энэ нь Юань гүрэн болон дараа үеийн монголын төр, монголчуудын дунд шашны нөлөө нэлээдгүй туссан гэдгийг харуулж байна.

Харин үйл үгийн хувьд нийт 22 үг тохиолдож байгаагаас *бүтээх* гэдэг үг хамгийн олонтоо буюу 100 удаа тохиолдох бөгөөд түүний дараа *номлох*, *түшигдэх*, *гутах*, *шантрах*, *сүслэх* гэх мэт үг 20-иос дээш удаа давтагдаж байна. Харин туслах үгээс *тулд*, *түүнчлэн*, *үй* (~ *олон*) гэсэн 3 үг тохиолдох бөгөөд монгол бичгээр буй дурсгалд *түүнчлэн* хэмээх холбох үг “ирсэн” гэдэг үгтэй нийлж “түүнчлэн ирсэн” буюу бурхныг заасан утгаар 4 удаа тохиолдож байна.

Энэ мэтээс дүгнэн үзэхэд дөрвөлжин болоод монгол бичгээрх дурсгалын нийтлэг үгийн сангийн бүрэлдэхүүнд уугуул үг дийлэнх нь байх бөгөөд харь хэлний үг цөөн тохиолдож байна. Утгын талаас шашинтай холбоотой албан тушаал, үг хэллэг, шашны үйл явдлыг заасан үгс байх бөгөөд эд хэрэглэл, амьтан ургамал зэргийг заасан үг огт тохиолдохгүй байна. Түүнчлэн тус хоёр бичгээр бичигдсэн дурсгалын нийт үгийн сангийн 80 гаруй хувь (110 үг) нь орчин цагийн монгол хэлний идэвхтэй хэрэглээний үгс байна.

В. Монгол ба араб-перс бичгээрх дурсгалын нийтлэг үг. Дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалуудын үгийн санд нийтлэг тохиолдох үгсээрээ монгол-хятад бичгээр буй дурсгалын дараа орох бөгөөд 275 үг байна. Тэдгээр үгийн дотор мөн уугуул үг зонхилж байх бөгөөд түрэг, уйгур, грек, манж түнгүс, перс, хятад хэлнээс орж ирсэн 17 үг тохиолдож байна. Тэр дунд түрэг, уйгур хэлний үг зонхилох бөгөөд уйгур хэлний *эш, эрлэг*; түрэг хэлний *таар, хивэг, хөв, яр* гэсэн үг тохиолдож байна. Энд дурдсан үгсийг ажиглахад уйгураас шашны холбогдол бүхий үг, түрэгээс ахуй амьдралтай холбоотой үг орж ирсэн нь тодорхой харагдана.

Уугуул үгийн хувьд үйл үг зонхилох бөгөөд монгол, дөрвөлжин бичгээрх дурсгалын үгийн санд шашны холбогдолтой үйл үг зонхилж байсан бол монгол, араб-перс бичгээр буй дурсгалын үйл үг нь илүү иргэний буюу өдөр тутмын ахуй амьдрал, хүний бие, сэтгэлийн үйлийг заасан үгс зонхилж байгаагаараа онцлогтой юм. Тухайлбал, *хэлэх, угаах, бөөлжих, наадах, орчуулах, долоох, гайхах, өнгөрүүлэх* гэх зэрэг үг хамгийн олон давтамжтай байна.

Нэр үгийн хувьд ч мөн адил шашинтай холбоотой үг хэллэг бараг тохиолдохгүй бөгөөд эд зүйл, ажил мэргэжил болоод хүний дотоод сэтгэлтэй холбоотой үг хэллэг олонтоо тохиолдоно. Жишээлбэл, *алх, арчуур, араг, гэрч, идэгч, хийгч, баясгалан, хүсэл, санаа* гэх мэт. Харин давтамжийн хувьд нэр үгийн дотор *үлэмж* хэмээх үг хамгийн олон давтагдах бөгөөд үүний дараа *цол, үсэг, залуу, шороо, үхэл, явагч* гэх мэт үг байна. Мөн “-ч” болон “-гч” дагавраар бүтсэн ажил мэргэжил хийгээд үйлийн эзнийг заасан үг бусад бичгээрх үгийн сангаас хавьгүй олон байгаа нь ажиглагдана. Жишээлбэл, ажил мэргэжил заасан *борч, даргач, төмөрч, гуйранч* гэх мэт үг байгаа бол үйлийн эзнийг заасан *хэллэгч, бологч, идэгч, занчигч, хийгч, хүргэгч, сахигч, тайгч* гэх мэт үг тохиолдоно.

Ер нь монгол ба араб-перс хоёр бичгээр бичигдсэн дурсгалуудад нийтлэг тохиолдох үгийн сангийн давтамжийг ажиглахад “монгол-хятад”, “монгол-дөрвөлжин”, “хятад-араб” гэсэн олон үгтэй үгийн санг бодвол нэг үгийн давтагдах тоо нь харьцангуй бага байна. Тодруулбал, дээр дурдсан гурван зүйлийн нийтлэг үгийн санд хамгийн их давтамжтай үгс нь 100-аас дээш давтагдаж байхад тус хоёр бичгээрх (монгол-араб) нийтлэг үгийн сангийн хамгийн олон давтамжтай үг нь *хэлэх* гэдэг үг бөгөөд 63 удаа, *үлэмж* хэмээх үг 53 удаа л тохиолдож байна. Харин бусад үг нь 50-иас бага давтагдаж байгаа юм.

Энэ мэтээс үзэхэд тус нийтлэг үгийн санд шашны холбогдолтой үг хэллэг бараг тохиолдохгүй бөгөөд илүү иргэний, өдөр тутмын амьдралтай ойр үгийн сан байгаагаараа онцлогтой юм. Түүнээс гадна давтамжийн хувьд нэг үгийн давтагдах тоо бусад бичгээрх үгийн сангийн давтамжаас харьцангуй бага байгаа нь нэг талаар араб бичгээр буй дурсгалын үгийн сантай холбоотой нөгөө талаар тухайн үеийн бичгийн хэлэнд эдгээр үгийг тийм ч өргөн хэрэглэдэггүй байжээ гэж үзэж болохоор байна. Харин орчин цагийн монгол хэлний үгийн сангийн үүднээс үзвэл, тус нийтлэг үгийн сангийн 85% нь одоо ч идэвхтэй хэрэглэгдсээр байх бөгөөд тус санд *Толуй* хэмээх нэрээс өөр оноосон нэр тохиолдохгүй.

Г. Хятад ба араб-перс бичгээрх дурсгалын нийтлэг үг. Хятад болон араб-перс бичгээр уламжлагдан ирсэн дурсгал бичгүүдэд нийтлэг тохиолдох 246 үг байх бөгөөд үүнээс 14 нь харь гаралтай үг байна. Тэдгээр харь үгийн дотор түрэг хэлнээс орж ирсэн үг зонхилох бөгөөд ихэвчлэн амьтны нэрс байх ажээ. Жишээлбэл, *хавлан (нэг зүйл бар), хулан, ширх (амьтны бөөс), хачир (~ тас), хоридай (хотон шувуу)* гэх мэт.

Харин үгийн аймгийн хувьд 70 орчим хувийг нэр үг эзлэх ба *хэвтүүл* хэмээх үг хамгийн олон давтамжтай буюу 108 удаа тохиолдож байна. Үүнээс гадна тус хоёр бичгээрх дурсгалд морь мал, түүний зүс, уналга эдэлгээний зүйлс, хувцас хунар хийгээд хүний эд эрхтэн зэрэгтэй холбоотой үг нэлээдгүй тохиолдож байгаагаараа бусад нийтлэг үгийн сангаас ялгаатай байгаа юм. Тухайлбал, адуу малтай холбоотой *цүлбуур, дэл, уурга, дөрөө, гөлөм, жирэм, хөмөлдөрөг, хударга, минаа, хөхүүр, ногт, олом, намбага, өтөг, айраг, бэлэвсэн, шарга, халз, хом, хоног* гэх мэт үг байхад зэр зэвсэгтэй холбоотой *зэвсэг, хөрөө, хадуур, шөвөг, үлдэт* гэх мэт, хувцас хунартай холбоотой *малгай, нэхий,*

нударга, өлгий, өмд, ханцуй, хормой гэх мэт харин хүний бие эрхтэнтэй холбоотой *хацар, сормуус, судас, гээг, борви, дэлүү, гүя, бөгс, ал, шилбэ, өсгий* гэх мэт утгат үг зонхилж байна.

Үйл үгийн хувьд *дагуулах, орхих, дутаах, элсэх, хугалах, талах, бүчих, занчих* гэх мэт дайн тулааны үйлийг заасан үг олон давтамжтай байх бөгөөд ийм утга агуулгатай үйл үг үгийн санг бүрдүүлж байна.

Хятад болон араб-перс бичгээр буй дурсгалын нийтлэг үгийн санг орчин цагийн монгол хэлний хэрэглээний талаас авч үзэхэд 90% нь идэвхтэй үг байх бөгөөд үлдсэн хувь нь идэвхгүй хийгээд бэрх үгийн санд багтах үгс байна. Гэхдээ тэдгээр үгсийн зарим нь нутгийн аялгуунд хадгалагдан үлджээ. Жишээлбэл, араб-перс бичгээрх дурсгал болох “The King’s Dictionary. The Rasulid Hexaglot” толь бичгийн 205-р зүйлд (Peter Golden, 2000: 302), хятад бичгээрх дурсгал болох “Хуа-и и-юй” (Songqur, 2017) толь бичигт тохиолдох *цараг* (саруу) хэмээх үг нь адуу, үхрийн ширээр хийсэн нэг зүйл гутлыг хэлдэг (mongoltoli.mn). Гэвч тус үгийг нийт монголчуудын дунд түгээмэл хэрэглэхгүй боловч баруун монголчууд, тэр дундаа торгууд ардын дунд одоо ч хэрэглэж, тэрхүү гутлыг өмсдөг бөгөөд “тоокуу гог” ч хэмээн нэрлэдэг байна. Мөн “Монголын нууц товчоон”-ы 77-р зүйлд *bekter hulqun de’er-e sirqa aqta-tan yisün mori qaraḡu sayun бүкүи-дүр* (Rachewiltz, 1972:29) [Бэгтэр улхун дээр шарга агттан есөн морь харж суун бүхүйд] (Чоймаа, 2011: 36) хэмээхэд гарч буй “улхан” хэмээх үг нь “довцог, толгой”-г хэлэх бөгөөд өдгөө буриадууд ийн хэлэлцсээр байна.

Энэ мэтээс үзэхэд тус нийтлэг үгийн санд дайн тулаантай холбоотой нэр, үйл үг олонтоо байхаас гадна адууны зүс, ачлага уналгын эд хэрэглэл болон хүний бие эрхтний нэрс зонхилж байгаагаараа бусад сангаас ялгаатай. Мөн түүнчлэн орчин цагийн монгол хэлний халх аялгуунд хэрэглэгдэхээ болсон ч бусад нутгийн аялгуунд хадгалагдан үлдсэн үгс цөөнгүй байх бөгөөд тус санд оноосон нэр тохиолдохгүй нь онцлог юм.

Д. Хятад ба дөрвөлжин бичгээрх дурсгалын нийтлэг үг. Хятад болон дөрвөлжин бичгээр буй сурвалжуудын үгийн санг харьцуулахад нийтлэг тохиолдох 19 үг байна. Тус хоёр бичгээрх дурсгалын хувьд бусад бичгээр буй дурсгалтай харьцуулан бодвол үгийн сан нь ойр байх мэт сэтгэгдэвч эдгээр дурсгалууд нь иргэний болон албаны шинжтэй учир тохирох үг цөөн ажээ. Учир нь дөрвөлжин бичгийн дурсгалууд нь хаад, хятад болон эрхтэн тушаалтны зарлиг, албан захидал, хөшөө чулууны бичиг зэрэг дурсгал голлох тул ихэвчлэн төр улсын холбогдол бүхий албан бичгийн үг хэллэг голлож байна. Харин хятад бичгээрх монгол хэлний дурсгалын хамгийн их үгийн сантай дурсгал болох “Монголын нууц товчоон” нь түүх-уран зохиолын шинжтэй сурвалж, нөгөө нь “Хуа-и и-юй” буюу толь бичиг учир үг хэллэгийн хувьд тохирох нь ийн цөөн байх аж.

Үгийн аймгийн хувьд тус санд жинхэнэ нэр, үйл үг олон байх боловч тооны нэр, туслах үг тохиолдохгүй. Түүнээс гадна 4 оноосон нэр байх бөгөөд хятад гаралтай *сэгүсэ* (següse) хэмээх үгээс өөр харь хэлний үг тохиолдохгүй. Энэхүү *сэгүсэ* хэмээх үг нь “залуу зарц” (Serrus, 1974: 319-325) гэсэн утгатай бөгөөд “Монголын нууц товчоон” -д хоёронтоо (Rachewiltz, 1972:306) тохиолдох ажээ.

Орчин цагийн монгол хэлний үүднээс авч үзэхэд хятад ба дөрвөлжин бичгээр буй дурсгалд нийтлэг тохиолдох 19 үгээс *хигүл*- (kigül-), *мухури*- (muquri-) хэмээх хоёр үйл үгээс бусад үг нь идэвхтэй хэрэглэгдэж байна. Жишээлбэл, *горхи* (γoγuq-a), *мөд* (möd), *мөн* (mön), *алдуул*- (aldaγul-), *хай*- (qayı-) гэх мэт үгс олон давтагдаж байна.

Е. Дөрвөлжин ба араб-перс бичгээрх дурсгалын нийтлэг үг. Нийтлэг тохиолдох үгийн сангийн дотор хамгийн цөөн үг тохирч байгаа нь дөрвөлжин ба араб-перс бичгээр буй дурсгалуудын үгийн сан бөгөөд *зарчим, зарлигт, удуул*- хэмээх гурван үг л тохирч байна. Ер нь дөрвөлжин бичгийн дурсгалуудын үгийн сан бусад бичгээр буй дурсгалын үгийн сангаас харьцангуй бага учраас бусад сурвалжуудтай харьцуулахад үгийн сангийн тохирох буюу нийтлэг үг тун цөөн тохиолдох ажээ.

Дүгнэлт

Дээрх бүгдээс дүгнэн үзэхэд хоёр өөр бичиг үсгээр уламжлагдан ирсэн дурсгал бичгүүдийн нийтлэг үгийн санд уугуул үг зонхилох бөгөөд харь хэлний үг цөөн тохиолдох ажээ. Тодруулбал, нийт үгийн сангийн 82 үг буюу 6% нь харь гаралтай үг байх ба ихэнх нь түрэг, уйгур хэлний үг байна. Энэ нь бидний өвөг дээдэс эх хэлээ эрхэмлэн дээдэлж байсан бөгөөд зайлшгүй тохиолдолд л харь үг авдаг байсныг гэрчилж байна. Харин үгийн аймгийн хувьд 63 хувийг нэр үг эзлэх бөгөөд үүн дотор жинхэнэ нэр голлох хувийг эзэлнэ. Үйл үгийн хувьд 35%-ийг эзлэх бөгөөд туслах үг 2%-ийг л эзлэх ажээ.

Дундад үеийн монгол хэлний бичгийн сурвалжуудыг бичиг бүрээр нь багцлан, тэдгээрийн үгийн санг харьцуулан үзэхэд утгын талаас бүгд өөр өөр онцлог шинжийг хадгалж байна. Энэ нь тухайн бичгээр буй сурвалжийн утга агуулга хийгээд улс үндэстний соёлоос хамаарч буй нь бидний гаргасан жагсаалтаас тодорхой харагдана. Тухайлбал, дөрвөлжин ба монгол бичгээрх дурсгалын нийтлэг үгийн санг харьцуулахад ихэнх нь шашны холбогдол бүхий үг хэллэг байх бөгөөд эд зүйл, ан амьтан, ургамал ногооны нэр огт тохиолдохгүй. Харин хятад болон араб-перс бичгээрх дурсгалын нийтлэг үгийн санд амьтан тэр дундаа адуутай холбоотой үг, хүний бие эрхтний нэрс зонхилж байх жишээтэй. Энэ мэтчилэн бичиг тус бүрийн утгын харьцууллыг орчин цагийн монгол хэлний хэрэглэгдэх байдалтай нэгтгэн үзүүлбэл дараах мэт байх ажээ.

Бичиг тус бүрийн харьцуулал	Тохиолдох нь	Тохиолдохгүй нь	ОЦМХ-нд идэвхтэй хэрэглэгдэх нь
Монгол - хятад	Маш өргөн бөгөөд бүхий л талын үг хэллэгийг багтаасан үг		80 орчим %
Монгол - дөрвөлжин	шашин, албан тушаалын үг	эд хэрэглэл, амьтан ургамлын нэр	80 гаруй %
Монгол - араб, перс	өдөр тутмын ахуй амьдралтай холбоотой үг	шашны холбогдол бүхий үг	85%
Хятад - араб, перс	морь мал, түүний зүс, уналга эдэлгээний зүйлс, хувцас хунар хүний эд эрхтэн дайн тулааны үйл заасан үг	шашин, төр улс, албан тушаалын нэр	90%
Хятад - дөрвөлжин	албан бичгийн үг	шашин, амьтан ургамал, эд зүйлийн нэр	88%
Дөрвөлжин - араб, перс	албан бичгийн үг	шашин, амьтан ургамал, эд зүйлийн нэр	100%

Хүснэгт 1. Нийтлэг үгийн утга, хэрэглээний харьцуулал

Дээрх хүснэгтээс үзэхэд дундад үеийн монгол хэлний бичгийн дурсгалд тохиолдох үгсийг давтамж буюу хэрэглээ талаас нь авч үзэхэд нийтлэг тохиолдох үгсийн ихэнх нь буюу дунджаар 87% нь орчин цагийн монгол хэлний идэвхтэй үг байсаар байна. Үүнээс үзэхэд бичгийн дурсгалаар уламжлан ирсэн эдгээр нийтлэг үг нь орчин цагийн монгол хэлний үүднээс уугуул үг мөн бөгөөд цөөн тооны харь үг байгаа ч тэдгээр нь монгол хэлэнд шингэсэн шингэмэл үг болох юм. Харин дундад үеийн монгол хэлний хувьд тухайн үеийнхээ хамгийн өргөн хэрэглээний үг байсан, өнөөдөр ч бас байсаар байгаа нь харагдаж байна. Мөн түүнчлэн XIII зуунаас өнөөг хүртэлх монгол хэлний үгийн санд шинэ үг хэллэг нэмэгдсэнээс бус мартагдаж, үлдэж хоцорсон нь маш бага байх ажээ. Үүнээс аливаа хэлний бичгээр уламжлагдан ирсэн

уугуул үгийн сангаас үг хасагдаж мартагдах үйл явц маш удаан хугацааны үзэгдэл байдаг гэж үзэж болохоор байна.

Резюме

Множество монгольских и зарубежных ученых в течение длительного времени изучали лексику монгольского языка со всех сторон, и до сих пор продолжают активно писать и публиковать множество статей и исследований по данной теме. Подобные исследования часто ограничиваются проблемами, связанными с этимологией слов, изучением конкретных исторических источников и лексикой современного монгольского языка. Однако до сих пор не издана лексическая база, объединяющая лексику многих письменных исторических источников монгольского языка.

В данной статье мы провели сопоставительный анализ лексики более чем 270 наследственных памятников, написанных на старомонгольском, квадратном, арабо-персидском и китайском письменностях. При этом, на основе данной лексики, помимо уточнения наиболее употребительных слов того времени, мы рассмотрели общеупотребительные слова с точки зрения их происхождения, части речи, лексического значения и употребления в современном монгольском языке.

Ном зүй

- Баттөгс Ш., Пүрэвжав Э., Гэрэлмаа Г., Шинэбаяр О., Ганболд Д.** 2020. *Монгол хэлний үгийн сан найруулга судлал*. Монгол хэл судлалын түүх, III боть. Улаанбаатар. 15-242.
- Баттөгс Ш., Пүрэвжав Э., Түвшинтөгс Б., Гэрэлмаа Г., Шинэбаяр О., Ганболд Д.** 2022. *Үгийн сан, утга, найруулга судлал-I*. Монгол хэл судлал XV боть. Улаанбаатар. 15-69.
- Өнөрбаян Ц., Цог-Очир А., Жумдаан Л.** 2020. *Орчин цагийн монгол хэл*. Улаанбаатар., 2020. 180.
- Сүхбаатар О.** 2014. *Монгол хэлний харь үгийн толь*. Улаанбаатар. 7.
- Төмөртоого Д.** 2022. Түүхэн хэл зүй-V. *Монгол хэл судлал XV боть*. Улаанбаатар., 341-400;
- Чоймаа Ш.** 2011. *Монголын нууц товчоо эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг*. Улаанбаатар., 43.
- Шагдарсүрэн Ц., Бадамдорж Д., Самбуудорж О., Пүрэвжав Э., Баттөгс Б., Гэрэлмаа Г.** 2022. *Үгийн сан, утга зүй*. Монгол хэл судлал цувралын X боть. Улаанбаатар. 27-70.
- Шагдарсүрэн Ц. Даваасүрэн Б., Цэцэгдарь Г., Түвшинтөгс Б., Батдорж Ц., Батхишиг С.** *Үсэг зүй*. Монгол хэл судлал цувралын VII боть. Улаанбаатар. 187-227.
- Golden Peter B.** 2000. *The King's Dictionary*. The Rasulid Hexaglot. Köln. 302.
- Mel'čuk I.** 1995. *Phrasemes in Language and Phraseology in Linguistics*. New York. 167-232.
- Rachewiltz, Igor de.** 1972. *Index To The Secret History of the Mongols*. Indiana university. Bloomington., 29, 306.
- Serryus H.** 1974. *Hsiao-ssu: Seüse, A Chinese loan word in Mongol*. AOH. Vol. 28. №3. Budapest., 319-325.
- Šongqur A.** 2017. *Quwa i i iiii bičig [Хуа-и и-юй бичиг]*. Kökeqota.
<https://mongoltoli.mn>